

**МОНГОЛ АРДЫН НАМЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ
БАЙДЛЫН ТАЛААР ТАЙЛАН
(2020-2022 он)**

1. ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8.4 дэх хэсэгт “Улс төрийн нам нь энэ хуулийн 8.2, 8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18.1-д заасан Жендэрийн Үндэсний Хороонд хоёр жил тутам хүргүүлж байна” гэж заасны дагуу 2020–2022 оны Жендэрийн эрх тэгш байдлын тайланг Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлийн Ажлын албанаас бэлтгэн хүргүүлж байна.

2. МОНГОЛ АРДЫН НАМЫН ТУХАЙ

Монгол Улсад Монгол Ардын Намын 22 дунд шатны байгууллага (НДШБ), 2821 намын анхан шатны байгууллага (НАШБ) үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 286,648 гишүүн цахим бүртгэл хийлгээд байна.

3. МАН-ЫН ӨӨРИЙН ТӨЛӨӨЛЛИЙН ТӨВ БОЛОН ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР

Монгол Ардын Намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүн дэх тоон судалгааг нэгтгэхдээ хамрах хүрээг дараах байдлаар ангиллаа. Үүнд:

1. Намын гишүүдийн нас, хүйсийн байдал
2. Намын удирдах албан тушаал
3. Төрийн улс төрийн албан тушаал

3.1. Монгол Ардын Намын гишүүдийн нас, хүйсийн байдал

Монгол Ардын Намын гишүүнчлэлийн цахим бүртгэлд 286 648 гишүүн байна.

Намын гишүүдийн нас, хүйсийг хүснэгтээр:

	Нийт		18-25 нас		26-35 нас		36-55 нас		56-аас дээш	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Хүйс	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Гишүүд	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Хувь	130066	156582	7342	7893	24603	23387	55440	65275	41103	61605
Нийт	45.4		54.6		48.2		51.8		51.3	

3.2. Монгол Ардын Намын Удирдах байгууллагад сонгогдож, томилогдсон албан тушаалтны хүйсийн байдал:

Намын байгууллага	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Эзлэх хувь (эмэгтэй)
ХХХ Хурал	1245	950	295	23.7
Хяналтын Ерөнхий хороо	21	17	4	19.0
Бага хурал	479	378	101	21.1
Удирдах Зөвлөл	37	27	10	27
Удирдах Зөвлөлийн Ажлын албаны удирдлага	25	17	8	32
Удирдах Зөвлөлийн Ажлын алба	161	80	82	50.9
Нийт	1968	1469	500	25.4

Монгол Ардын Намын дэргэдэх төрийн бус байгууллагын Удирдах Зөвлөлд хүйсийн байдал:

№	Дэргэдэх холбоод	Удирдах Зөвлөлийн гишүүн	Эрэгтэй	Эмэгтэй	Эзлэх хувь
1	Ахмадын холбоо	37	31	6	16.2
2	СДМЭХ	71	0	71	100.0
3	СДМЗХ	72	59	13	18.1
4	СДМОХ	39	27	12	30.8
	Нийт	219	117	102	46.5

Дүгнэлт-1: Монгол Ардын Намын Удирдах төв байгууллагын хүйсийн харьцаа эмэгтэй 25.4 хувь, эрэгтэй 74.6 хувь, дэргэдэх төрийн бус байгууллагын удирдах дээд байгууллагад эмэгтэй 46.5 хувь, эрэгтэй 53.5 хувь тус тус байна. Нийт эмэгтэй хүйсийн төлөөлөл 602 буюу 26.2 хувь байх тул Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан шаардлагыг хангаж байна.

Түүнчлэн МАН-ын Үндсэн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5.8-д “Намын бүх шатны сонгуульт байгууллагад 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна” гэж заасан сайн дурын квотын шаардлагыг хангаагүй. Иймд Удирдах төв байгууллага болон дэргэдэх төрийн бус байгууллагын (СДМЭХ-ноос бусад) Удирдах Зөвлөлийн эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлд анхаарч, бодлого гарган ажиллаж байна.

3.2.3. Намын орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүний тухайд

Аймаг, нийслэл, дүүргийн Монгол Ардын Намын хорооны эмэгтэй дарга, дэд дарга хүснэгтээр:

д/д	Аймаг	Намын хорооны дарга (эмэгтэй)	Намын хорооны дэд дарга (эмэгтэй)	Хувь
1	Архангай	0	0	0.0
2	Баян-Өлгий	0	0	0.0
3	Баянхонгор	0	0	0.0

4	Булган	0	0	0.0
5	Говь-Алтай	0	0	0.0
6	Говьсүмбэр	0	1	3.2
7	Дархан-Уул	0	0	0.0
8	Дорноговь	0	0	0.0
9	Дорнод	0	0	0.0
10	Дундговь	0	0	0.0
11	Завхан	0	0	0.0
12	Орхон	0	0	0.0
13	Өвөрхангай	0	0	0.0
14	Өмнөговь	0	0	0.0
15	Сүхбаатар	0	0	0.0
16	Сэлэнгэ	0	0	0.0
17	Төв	0	0	0.0
18	Увс	0	0	0.0
19	Ховд	0	0	0.0
20	Хөвсгөл	0	0	0.0
21	Хэнтий	0	0	0.0
22	Нийслэл	0	0	0.0
23	Багануур	0	0	0.0
24	Багахангай	0	0	0.0
25	Баянгол	0	1	3.2
26	Баянзүрх	0	0	0.0
27	Налайх	0	0	0.0
28	Сонгинохайрхан	0	1	3.2
29	Сүхбаатар	0	1	3.2
30	Хан-Уул	0	0	0.0
31	Чингэлтэй	0	0	0.0
	НИЙТ	0	4	12.8

Аймаг, нийслэл, дүүргийн Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгчдийн эрэгтэй, эмэгтэй эзлэх хувь хүснэгтээр:

д/д	Харьяалал	Тэргүүлэгчдийн тоо	Эр	Эм	Хувь
1	Архангай	19	13	6	31.6
2	Баян-Өлгий	23	21	2	8.7
3	Баянхонгор	23	17	6	26.1
4	Булган	23	18	5	21.7
5	Говь-Алтай	21	17	4	19.0
6	Говьсүмбэр	17	15	2	11.8
7	Дархан-Уул	21	18	3	14.3
8	Дорноговь	21	15	6	28.6
9	Дорнод	23	20	3	13.0
10	Дундговь	19	17	2	10.5
11	Завхан	17	14	3	17.6
12	Орхон	23	20	3	13.0
13	Өвөрхангай	15	12	3	20.0
14	Өмнөговь	23	16	7	30.4
15	Сүхбаатар	21	19	2	9.5
16	Сэлэнгэ	21	15	6	28.6
17	Төв	17	13	4	23.5
18	Увс	23	21	2	8.7
19	Ховд	23	19	4	17.4

20	Хөвсгөл	23	20	3	13.0
21	Хэнтий	21	19	2	9.5
22	Нийслэл	23	21	2	8.7
23	Багануур	15	12	3	20.0
24	Багахангай	15	10	5	33.3
25	Баянгол	11	10	1	9.1
26	Баянзүрх	15	10	5	33.3
27	Налайх	13	11	2	15.4
28	Сонгинохайрхан	15	11	4	26.7
29	Сүхбаатар	15	15	0	0.0
30	Хан-Уул	13	11	2	15.4
31	Чингэлтэй	15	12	3	20.0
НИЙТ		587	482	105	17.9

Аймаг, дүүргийн дэргэдэх ТББ-ын салбар холбоод:

№	Харьяалал	Ахмадын холбоо (эмэгтэй)	СДМЗХ (эмэгтэй)	СДМОХ (эмэгтэй)
1	Архангай	5	5	8
2	Баян-Өлгий	6	6	4
3	Баянхонгор	3	2	14
4	Булган	6	5	7
5	Говь-Алтай	6	4	8
6	Говьсүмбэр	6	4	2
7	Дархан-Уул	5	9	6
8	Дорноговь	9	8	8
9	Дорнод	5	6	4
10	Дундговь	3	7	8
11	Завхан	8	8	6
12	Орхон	13	4	7
13	Өвөрхангай	3	2	5
14	Өмнөговь	5	4	3
15	Сүхбаатар	4	6	5
16	Сэлэнгэ	3	3	8
17	Төв	2	3	4
18	Увс	1	9	6
19	Ховд	2	8	10
20	Хөвсгөл	4	6	8
21	Хэнтий	7	5	6
22	Баянгол	5	4	4
23	Баянзүрх	2	8	5
24	Хан-Уул	4	4	6
25	Сонгинохайрхан	8	4	0
26	Сүхбаатар	4	6	0
27	Чингэлтэй	4	8	7
28	Багануур	7	10	4
29	Багахангай	7	7	10
30	Налайх	7	10	8
НИЙТ		154	175	181

Монгол Ардын Намын үндсэн дүрмийн 8.2. дахь заалтад “НАШБ нь нийслэлд дүүргийн намын хороо, хорооны намын хороо, үүр; аймагт сумын намын хороо, үүр,

багийн намын үүр байна” гэж заасан. Намын гишүүнчлэл, гишүүдийн бүртгэл мэдээлэл, тэдний намын үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, намаас иргэдтэй харилцах, намын бодлого шийдвэрийг тэдэнд хүргэх үйл ажиллагааг сум, хорооны нутаг дэвсгэрт явуулах намын бүтцийн анхан шатны нэгж нь намын үүр; аймаг, нийслэлд дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа намын хороо, үүрүүдийг нэгдмэл зохион байгуулалт, удирдлагаар хангах үүрэг бүхий нэгж нь сум, дүүрэг, хорооны намын хороо байна.

д/д	Аймаг	Сум/дүүргийн НХ-ны дарга			Үүрийн дарга		
		Сум	Эр	Эм	Үүрийн дарга	Эр	Эм
1	Архангай	19	19	0	101	87	14
2	Баян-Өлгий	13	13	0	99	87	12
3	Баянхонгор	20	19	1	105	80	25
4	Булган	17	15	2	79	50	29
5	Говь-Алтай	20	19	1	88	67	21
6	Говьсүмбэр	3	3	0	10	7	3
7	Дархан-Уул	4	4	0	35	22	13
8	Дорноговь	16	16	0	66	36	30
9	Дорнод	14	13	1	74	41	33
10	Дундговь	15	14	1	68	47	21
11	Завхан	24	20	4	116	85	31
12	Орхон	2	2	0	26	17	9
13	Өвөрхангай	19	17	2	112	83	29
14	Өмнөговь	15	14	1	57	39	18
15	Сүхбаатар	13	10	3	67	44	23
16	Сэлэнгэ	17	15	2	58	39	19
17	Төв	27	21	6	109	71	38
18	Увс	19	19	0	96	76	20
19	Ховд	17	16	1	93	73	20
20	Хөвсгөл	24	23	1	146	106	40
21	Хэнтий	20	17	3	104	60	44
22	<i>Багануур</i>	5	4	1	11	10	1
	<i>Багахангай</i>	2	0	2	4	2	2
	<i>Баянгол</i>	25	19	6	108	48	60
	<i>Баянзүрх</i>	43	35	8	125	23	102
	<i>Налайх</i>	8	5	3	17	11	6
	<i>Сонгинохайрхан</i>	43	25	18	101	25	76
	<i>Сүхбаатар</i>	20	16	4	65	29	36
	<i>Хан-Уул</i>	25	20	5	65	50	15
<i>Чингэлтэй</i>	24	15	9	74	31	43	
НИЙТ		533	448	85	2279	1446	833
		100	84.0	16.0	100	63.4	36.6

Дүгнэлт-2: Монгол Ардын Намын орон нутгийн байгууллагын удирдлагын түвшинд эмэгтэй 1027 буюу 30 хувь, эрэгтэй 2403 буюу 70 хувь тус тус байх тул Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан

шаардлага, МАН-ын Үндсэн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5.8 дахь заалтын сайн дурын квотын шаардлагыг тус тус хангаж байна.

3.3. Монгол Ардын Намаас Төрийн улс төрийн албан тушаалд сонгогдож, томилогдсон албан тушаалтны эрэгтэй, эмэгтэй эзлэх хувь

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 11 дүгээр зүйлд заасан зарим албан тушаалын төрлөөр ангилан гаргалаа. Үүнд, 2020 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Ардын Намаас сонгогдож, томилогдсон Монгол Улсын Их хурлын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч нарыг хамруулсан болно.

Монгол Улсын Их хурал:

1992-2020 оны Улсын Их Хурлын 8 удаагийн сонгуульд 365 гишүүн (давхардаагүй тоогоор) сонгогдсон байна. Нийт эмэгтэй 45 гишүүн сонгогдсоноос 29 буюу 64.4 хувь нь Монгол Ардын Намаас сонгогдсон байна.

Улсын Их Хурлын 8 удаагийн сонгуулийн үр дүнг хүснэгтээр (эмэгтэй гишүүд):

	1992-1996	1996-2000	2000-2004	2004-2008	2008-2012	2012-2016	2016-2020	2020-2024
МАН	3	1	8	3	2	4	12	11
АН	-	7	1	1	-	6	1	2
ИЗНН	-	-	-	1	1	1	-	-
Нийт	3	8	9	5	3	11	13	13
Хувь	3.9%	10.5%	11.8%	6.5%	3.9%	14.4%	17.1%	17.1%

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

2020-2024 оны аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Монгол Ардын Намаас нэр дэвшсэн эмэгтэй гишүүн 178 буюу 21.8 хувь, үүнээс Монгол Ардын Намаас сонгогдсон эмэгтэй төлөөлөгч 82 буюу 17.5 хувь байна. Нийт 816 мандатаас 469 төлөөлөгч сонгогдсон бөгөөд сонгогдсон төлөөлөгчдийн дундаж нас 42 байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Ардын Намын төлөөлөгчдийн судалгааг хүснэгтээр: (2020 оны байдлаар)

№	Аймаг/	Мандатын тоо	Нэр дэвшсэн гишүүд (МАН)			Сонгогдсон төлөөлөгч (МАН)			
			эр	эм	Дундаж нас	Эр	Эм	Дундаж нас	
	Нийт	816	638	178	43	469	387	82	42
	Хувь	100%	78.2	21.8		57.50%	82.5	17.5	
1	Архангай	39	31	8	44	19	15	4	45
2	Баян-Өлгий	39	33	6	42	23	20	3	42
3	Баянхонгор	41	31	10	41	22	18	4	44
4	Булган	33	26	7	45	13	11	2	45
5	Говь-Алтай	41	32	9	42	11	10	1	39

6	Говьсүмбэр	17	14	3	42	10	8	2	37
7	Дархан-Уул	33	28	5	44	32	28	4	32
8	Дорноговь	33	25	8	43	28	22	6	42
9	Дорнод	37	29	8	45	26	22	4	44
10	Дундговь	35	28	7	42	11	8	3	42
11	Завхан	41	30	11	42	21	17	4	43
12	Орхон	35	28	7	40	23	20	3	40
13	Өвөрхангай	41	32	9	42	35	28	7	42
14	Өмнөговь	33	26	7	42	13	10	3	41
15	Сүхбаатар	33	23	10	46	6	5	1	49
16	Сэлэнгэ	37	29	8	47	23	20	3	43
17	Төв	41	30	11	44	26	18	8	45
18	Увс	41	32	9	44	17	16	1	43
19	Ховд	41	32	9	44	26	23	3	44
20	Хөвсгөл	41	32	9	44	18	15	3	41
21	Хэнтий	39	31	8	42	32	26	6	41
22	Нийслэл	45	36	9	40	34	27	7	40

Аймаг, нийслэлийн Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд Монгол Ардын Намаас сонгогдож, томилогдсон эмэгтэй дарга нарын тоог хүснэгтээр:

д/д	Аймаг / Нийслэл	АИТХ, НИТХ-ын дарга (эмэгтэй)		Аймаг, нийслэлийн Засаг дарга (эмэгтэй)		Аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч (эмэгтэй)	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Архангай	0	0.0	0	0.0	0	0.0
2	Баян-Өлгий	0	0.0	0	0.0	0	0.0
3	Баянхонгор	0	0.0	0	0.0	0	0.0
4	Булган	0	0.0	0	0.0	0	0.0
5	Говь-Алтай	0	0.0	0	0.0	0	0.0
6	Говьсүмбэр	0	0.0	0	0.0	0	0.0
7	Дархан-Уул	0	0.0	0	0.0	0	0.0
8	Дорноговь	0	0.0	0	0.0	1	4.5
9	Дорнод	0	0.0	0	0.0	0	0.0
10	Дундговь	0	0.0	0	0.0	0	0.0
11	Завхан	0	0.0	0	0.0	0	0.0
12	Орхон	0	0.0	0	0.0	0	0.0
13	Өвөрхангай	0	0.0	0	0.0	0	0.0
14	Өмнөговь	0	0.0	0	0.0	0	0.0
15	Сүхбаатар	0	0.0	0	0.0	0	0.0
16	Сэлэнгэ	1	4.5	0	0.0	0	0.0
17	Төв	0	0.0	0	0.0	0	0.0
18	Увс	0	0.0	0	0.0	0	0.0
19	Ховд	0	0.0	1	4.5	0	0.0
20	Хөвсгөл	0	0.0	0	0.0	0	0.0
21	Хэнтий	1	4.5	0	0.0	0	0.0
22	Нийслэл	0	0.0	0	0.0	0	0.0
	Нийт	2	9.0	1	4.5	1	4.5

Сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

2020 оны сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нийт 7353 мандаттайгаас Монгол Ардын Намаас 7334 гишүүн нэр дэвшсэн. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Ардын Намын төлөөлөгчдийн судалгааг хүснэгтээр: (2020 оны байдлаар)

№	Аймаг/ дүүрэг	Мандатын тоо	Нэр дэвшсэн	Нэр дэвшсэн гишүүд (МАН)			Сонгогдсон төлөөлөгч (МАН)			
				эр	эм	Дундаж нас	Нийт	эр	Эм	Дундаж нас
	Нийт	7353	7334	4971	2363	41	4007	2839	1168	40
	Хувь	100	99.7	67.8	32.2		54.5	71	29.1	
1	Архангай	433	433	302	131	41	199	142	57	40
2	Баян-Өлгий	329	329	277	52	41	176	152	24	40
3	Баянхонгор	418	418	310	108	41	201	160	41	37
4	Булган	340	340	218	122	43	153	107	46	38
5	Говь-Алтай	364	364	264	100	43	125	98	27	40
6	Говьсүмбэр	67	67	47	20	42	62	43	19	42
7	Дархан-Уул	106	106	62	44	43	93	54	39	44
8	Дорноговь	278	278	159	119	42	199	126	73	41
9	Дорнод	280	280	193	87	41	174	129	45	39
10	Дундговь	295	295	188	107	42	132	86	46	36
11	Завхан	452	449	309	140	41	270	192	78	41
12	Орхон	52	52	39	13	40	44	32	12	39
13	Өвөрхангай	447	447	300	147	40	298	213	85	40
14	Өмнөговь	313	308	206	102	43	117	89	28	42
15	Сүхбаатар	277	276	179	97	43	135	92	43	39
16	Сэлэнгэ	393	393	230	163	43	222	137	85	42
17	Төв	541	541	309	232	42	331	208	123	41
18	Увс	403	403	295	108	39	178	138	40	40
19	Ховд	371	367	275	92	41	192	149	43	42
20	Хөвсгөл	517	511	352	159	40	250	183	67	39
21	Хэнтий	386	386	245	141	41	255	167	88	41
1	Баянгол	41	41	31	10	39	21	16	5	39
2	Баянзүрх	42	42	33	9	36	23	19	4	39
3	Сүхбаатар	35	35	28	7	43	5	3	2	50
4	Сонгинохайрхан	43	43	29	14	40	42	28	14	40
5	Чингэлтэй	35	35	23	12	41	30	21	9	41
6	Хан-Уул	35	35	28	7	39	26	20	6	40
7	Багануур	17	17	12	5	43	16	11	5	43
8	Налайх	26	26	19	7	43	21	15	6	43
9	Багахангай	17	17	9	8	41	17	9	8	41

Томилогдон ажиллаж байгаа сум, дүүргийн Монгол Ардын Намын эмэгтэй Засаг дарга, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, сум, дүүргийн Засаг даргын орлогчийн тоог хүснэгтээр (МАН):

№	Аймаг	Сум	ИТХ-ын дарга (эмэгтэй)	Засаг дарга (эмэгтэй)	ЗД-ын орлогч (эмэгтэй)
1	Архангай	19	2	0	1
2	Баян-Өлгий	13	1	0	1
3	Баянхонгор	20	0	0	0
4	Булган	16	1	2	0
5	Говь-Алтай	18	0	0	0

6	Говьсүмбэр	3	1	1	0
7	Дархан-Уул	4	1	0	1
8	Дорноговь	14	2	1	2
9	Дорнод	14	0	1	0
10	Дундговь	15	2	1	2
11	Завхан	24	3	3	2
12	Орхон	2	0	0	0
13	Өвөрхангай	19	4	1	3
14	Өмнөговь	15	1	1	1
15	Сүхбаатар	13	1	1	1
16	Сэлэнгэ	17	5	1	2
17	Төв	27	4	7	2
18	Увс	19	0	0	0
19	Ховд	17	0	0	0
20	Хөвсгөл	23	2	0	0
21	Хэнтий	18	2	1	2
	Суманд нийт	330	35	21	23
		100%	10.6%	6.4%	7.0%
1	<i>Баянгол</i>	1	1	0	1
2	<i>Баянзүрх</i>	1	0	0	0
3	<i>Сүхбаатар</i>	1	0	0	0
4	<i>Сонгинохайрхан</i>	1	0	0	1
5	<i>Чингэлтэй</i>	1	0	0	0
6	<i>Хан-Уул</i>	1	0	0	0
7	<i>Багануур</i>	1	0	0	0
8	<i>Налайх</i>	1	1	0	1
9	<i>Багахангай</i>	1	1	0	1
	Дүүрэгт нийт	9	3	0	4
		100%	33.3%	0	44.4%

4. МОНГОЛ АРДЫН НАМААС БҮХ ШАТНЫ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДЭД ҮЗҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ТУХАЙ

Монгол Ардын Нам сонгуулийн холбогдох хууль, дүрэм журмын дагуу Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож, үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.

Улс төрийн аливаа шийдвэрт Монгол Ардын Нам хамтын удирдлага, дотоод ардчилалтай байх зарчимтай. Намын гишүүддээ сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгодог. Сонгуулийн сурталчилгааны үеэр нэр дэвшигчдэдээ ямар нэгэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай дүрэм, журам байхгүй.

---oOo---